

**Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үүсэл,
хөгжлийн зарим асуудалд**

М. Зулькафиль*

* МУИС, НУФ, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор

Монголын сэтгүүл зүйн хөгжилд ажиглагдаж буй шинэлэг хандлагын нэг бол эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх үүсвэр тавигдаж, цаашид эрчимтэй хөгжих нөхцөл боломж бүрдэж байгаа явдал юм. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй манайд нэн шинэлэг үзэгдэл мэт боловч дэлхий дахины сэтгүүл зүйн хувьд одоогоос 150 гаруй жилийн өмнө үүсчээ. Дэлхийн утга зохиол, сэтгүүл зүйн онол, түүхийг судлаачид 1879 онд хэвлэгдсэн Юхан Стринбергийн «Улаан тасалгаа», 1898 онд тагнуулын хэрэгт сэжиглэгдсэн Альфред Дрейфусын хэргийг эрэн сурвалжлах зорилгоор бичигдсэн Эмиль Золягийн «Би яллах болно» цуврал өгүүлэл, 1899 онд гарсан Теодор Вольфийн «Энэ чинь улс төр гэж үү?» зэрэг бүтээлүүдийг эрэн сурвалжлах аргаар бичигдсэн анхны бүтээлүүдийн тоонд оруулсан байдаг.

Гэхдээ энэ нь эрэн сурвалжлах ажлын анхны оролдлогууд байсан бөгөөд Барууны утга зохиол, сэтгүүл зүйд хүчтэй нөлөө үзүүлж чадаагүй юм.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй бүрэлдэн тогтож, олон нийтийг хамарсан томоохон үзэгдэл болж төлөвшихөд XIX зууны төгсгөл, XX зууны эхний үеийн америкийн уран бүтээлчид чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Америкийн сэтгүүл зүйд эрэн сурвалжлах үйл ажиллагааны эх суурийг тавьсан хүн бол «Территориэл энтерпрайз» сонинд өөрийнхөө бүтээлүүдийг Марк Твен хэмээх нууц нэрээр нийтлүүлж байсан Сэмюэл Клеменс (1835-1910) гэдгийг судлаачид хүлээн зөвшөөрдөг. Энэ хүн америкийн үндэсний утга зохиолыг үндэслэгчдийн нэг бөгөөд утга зохиолын ажлыг дагнан эрхлэхээс өмнө үсэг өрөгч, усан онгоцны замыг хянагч, сурвалжлагч зэрэг олон янзын мэргэжлээр ажиллаж байжээ. Түүний эрэн сурвалжлах үйл ажиллагааны онцлог шинж нь америкийн уран зохиолын уламжлалт арга болох аян замын тэмдэглэлийн төрөл зүйлээр бичигдэж, 1872 онд хэвлэгдэн гарсан «Нууц явдал» бүтээлд улам тод мэдрэгдсэн бөгөөд асар их хэмжээний баримт, материалд задлан шинжилгээ хийж, чухал асуудлуудыг дэвшүүлэн

тавьсанаараа олон түмний анхаарлыг татсан юм. Зохиогч нэгдүгээр биеэс өгүүлж, үйл явдлын оролцогч, гэрч болсон нь тухайн үеийн уран зохиолд нэлээд шинэлэг зүйл байжээ. Невада муж улсад газар авсан «мөнгөний төлөө тэмцэл» хэмээх хөдөлгөөнд оролцогч орон нутгийн өндөр албан тушаалтан, ажил хэрэгч хүмүүсийн хууль бус үйл ажиллагааг илчлэхэд зориулагдсан бүтээлийн ихэнх хэсгийг эрэн сурвалжлах аргын үр дүнд олсон баримт, мэдээлэл эзэлдэг.

Эрэн сурвалжлах ажлын үндсэн сэдвээс гадна энэ бичлэгийн төрөл зүйлийн бүх шинж тэмдгийг өөртөө агуулсан жижиг хэсэг бүхий **«мини-эрэн сурвалжлага»**-ыг оруулжээ. Тухайлбал, Невада муж улсын засгийн газрын бодлого болон захирагч засгийн газар хоёрын нууц харилцаа холбоо, хөрш зэргэлдээ Юта муж улсын мормон гаралтай хүн амын дундах ноцтой үйл явдал, Калифорнийн «мөнгөний төлөө тэмцэл»-ийн үйл ажиллагааны зарим баримтыг судалж, эрэн сурвалжилсан зэргийг хэлж болно. Энэ бүхний үр дүнд зохиогч сонины материал бус бүхэл бүтэн «баримтат роман» бичсэн бөгөөд үүнд Марк Твений аливаа уран бүтээлийн онцлог шинж болох бодитой болон таамаглан эрэн сурвалжлах ажлын хоёр үндсэн аргыг хослон хэрэглэсэн нь ажиглагддаг. Бодитой эрэн сурвалжлах явцад жинхэнэ эх сурвалжаас олж авсан **баримт бичгүүд, баталгаатай баримтууд, лавлах материалууд, сонины нийтлэлүүд** болон **гэрчүүдийн мэдээллийг** ашигласан бол таамаглан эрэн сурвалжлахад зохиомол баримт бичгүүд, мөнгөний

уурхайд тохиолддог янз бүрийн үйл явдал, явган шог, цуурхлын шинжтэй үг яриаг ашиглажээ. Ер нь М.Твен юмыг хэтрүүлж дүрслэх, өгүүлэх дуртай хүн байв. Гэхдээ таамаглал, элэглэл маягийн арга барил үйл явдлын ерөнхий уур амьсгал, бодит байдлыг төсөөлөхөд тусалдаг байсан нь жинхэнэ эрэн сурвалжлах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ.

Зохиогч мэдээлэл цуглуулах явцад орчин үеийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн практикт өргөн хэрэглэдэг зарим аргыг нэлээд оновчтой хэрэглэжээ. Тухайлбал, **«мэргэжил солих»** аргыг зохиогч аливаа үйл явдлын талаар лавшруулан өгүүлэх, олж авсан баримтыг нотлох явцад түгээмэл ашигладаг. Зохиогч «мөнгөний төлөө тэмцэл»-ийн тухай бүтээлээ Невадагийн хөгжил цэцэглэлийн урьдач нөхцлийг судлахаас эхэлдэг. Ингэхдээ олон түмний анхаарлыг татахуйц чухал баримтуудыг дэлгэн тавьж, «Невадагийн нутаг дэвсгэр»-ийг байгуулах тухай Конгрессээр баталсан хуулиас хүртэл иш татжээ. Үүний дараа үндсэн сэдэв рүү орж, 1858 онд Невадад мөнгөний томоохон орд байгааг илрүүлж, түүнд асар их хүн сайн дураараа нүүн суурьшиж, богино хугацаанд баяжиж эхэлсэн тухай өгүүлдэг. Тухайн үед хамгийн ядуу муж улсын нэг байсан Невадагийн засаг захиргааны албан тушаалтнууд энэ хууль бус үйл ажиллагаанд яаж оролцож, ямар аргаар баяжиж байсныг тодорхой баримт сэлтэд түшиглэн гаргажээ. Зохиогч заримдаа даргын нарийн бичгийн туслах, үйл явдалд оролцогч-уурхайчин, жирийн нэгэн туршлагагүй сонирхогч-ажиглагч, шинжээч, алт

хайгч, ажилчин болж «мэргэжлээ өөрчилсөн» нь мөнгөний хойноос улайран хөөцөлдөж, баяжихын төлөө жирийн хүмүүсээс эхлэн мужийн захирагч хүртэлх албан тушаалтнуудын юу ч хийхээс буцахгүй болсон хууль бус бохир заваан үйл ажиллагааг олон талаас нь нарийн судалж, чухал баримтуудыг дэлгэн тавьсан нь тухайн үед нийгмийг цочирдуулж байжээ. Хамгийн гол нь зохиогч үйл явдлыг дотроос нь харж, санхүүгийн баримт бичиг, мөнгө боловсруулах технологийн үйл явц, түүхийн лавлах материал, уурхайн бүтээгдэхүүний бүтэц, онцлог зэргийг **хөндлөнгийн ажиглалт, хувийн туршлага, орон нутгийн «шинжээчдийн» дүгнэлт** зэрэг үндсэн гурван эх сурвалжид тулгуурлан гаргасан нь урьд өмнө америкийн сэтгүүл зүйд ажиглагдаж байгаагүй нэн шинэлэг зүйл байсан юм. Хэрэв Марк Твений номон дахь «эрэн сурвалжлах элементүүд»-ийг бүдүүвч маягаар үзүүлбэл:

1. Сэдвийн оршил, дэвшүүлж буй үндсэн асуудлууд, түүний урьдач нөхцөл (уншигчдыг хууль эрх зүйн болон бусад баримтууд, мөн сонины нийтлэлүүдтэй танилцуулах),

2. Уншигчийг уурхай дахь ерөнхий нөхцөл байдалд «татан оруулж», тэдэнд мөнгө олборлох технологи болон «мөнгөний төлөө тэмцлийн уур амьсгал»-ыг харуулсан байдал (соины нийтлэлүүд, «шинжээчдийн» дүгнэлт),

3. Үндсэн хэсэг: «мөнгөний төлөө тэмцлийн» үед гарсан хууль бус үйл ажиллагааны дүр зураг (гэрчүүдийн мэдээлэл, сонины нийтлэл болон хувийн

туршлагад тулгуурлан үзүүлэх) зэрэг болно.

Ийм маягаар зохиогч өөрийнхөө бүтээлд зохиолчийн болон эрэн сурвалжлагчийн ер бусын гайхамшигтай авьяасыг гаргаж, олон түмний сэтгэл санааг зовоож буй үйл явдлыг маш нарийн, нягт нямбай судалж, тулгамдсан олон чухал асуудалд үндэслэл сайтай, тодорхой хариулт өгч чаджээ. Мөн түүний Ч.Уорнертэй хамтран бичсэн Америкийн нийгэмд халдварласан авилгал, хээл хахууль, ёс суртахууны ялзрал, шунахай сэтгэл зэргийг тусгасан алдарт «Алтлагдсан зуун» ном бас ийм онцлог шинжээрээ ялгардаг бөгөөд тухайн үед шуугиан дэгдээж байсан цөөн бүтээлийн нэг юм.

Марк Твен үндэс суурийг тавьсан хууль бус, үйл ажиллагаа, «бохир заваан бүхнийг илчлэн шүүмжлэх», эрэн сурвалжлах арга цаашид олон хүний уран бүтээлд нэвтэрч, амжилттай хөгжиж эхэлжээ. Энэ нь ялангуяа «бохир заваан бүхнийг илчлэгчдийн» үйл ажиллагаанд улам хүчтэй илэрсэн юм. Энэ ойлголт Америкт XIX зууны эцэст эдийн засаг хүчтэй хөгжиж, нийтийг хамарсан томоохон сэтгүүлүүд олноор гарч эхэлсэн үед бий болжээ. Тэдний дотор Бенжамин Флауэрийн эрхлэн гаргаж байсан «Талбар» (1887) сэтгүүл онцгой байр эзэлдэг. Өндөр боловсролтой, гүн гүнзгий сүсэг бишрэлтэй хүн болох Бенжамин Флауэр тухайн үеийн Америкийн бодит байдалд ихээхэн шүүмжлэлтэй ханддаг нэгэн ажээ. Америк оронд газар авсан баян ба ядуугийн эрс тэс ялгаа, авилгал, хээл

хахууль нь үндэстний ёс суртахууны доройтол гэж үзэж байв.

Б. Флауэр Америкийг ёс суртахууны хувьд дахин сэргэн мандуулахыг чухалчилж, «хэрэв хүмүүст бохир заваан үйл ажиллагааныхаа үр дагаварын талаар ойлгуулж өгвөл тэд алдаагаа засаж, сайн сайхан амьдрах болно» гэдгийг хатуу баримталдаг байжээ. Чухам ийм зорилгын үүднээс «Талбар» хэмээх сэтгүүлийг үүсгэн байгуулж, авилгал, томоохон хотуудын эрс тэс ялгаатай амьдрал, монополийн дарамт зэрэг тулгамдсан асуудлуудад анхаарлаа хандуулж эхэлжээ. Энэ сэтгүүл олон түмний анхаарлыг нийгмийн амьдралын бүх хүрээ салбар дахь эрх мэдэл, албан тушаалыг хэтрүүлэн хэрэглэж, нийгэмд хоруршиг тарьж буй аливаа хууль бус үйл ажиллагаанд хандуулахыг зорилго болгосон «бохир заваан бүхнийг илчлэгчдийн» дэвшилт хөдөлгөөний төлөөлөгч зохиолч, сэтгүүлчдийн үйл хэргийг шууд үргэлжлүүлэгч болж чадсан юм. Синклер, Стеффенс, Бэйкер, Тарбелл, Филлипс, Адамс, Салливен, Уайт зэрэг авьяаслаг сэтгүүлч энэ хөдөлгөөний хамгийн идэвхтэй гишүүд байв. Тэд шударга ёс ялах ёстой гэдэгт чин сэтгэлээсээ итгэж, бохир заваан үйлдлийн аливаа илрийг ямагт илчилж байх шаардлагатай гэж үзээд томоохон бизнесменүүд, санхүүгийн ажилтнууд, төр, засгийн түшмэлүүдийн иргэний ухамсрыг сэрээхийн төлөө хайр найргүй тэмцэж, хүн

«
*Авилгал, бусад хууль бус
үйл ажиллагаатай
тэмцэх гол хэрэгсэл бол
реформ гэж үзээд түүнд
ихээхэн найдвар тавьж
байсныг тэдний
нийтлэлүүдээс ажиглаж
болно.*

»

чанарын хэм хэмжээг өндөр төвшин баримтлахад уриалан дуудаж байгаа Авилгал, бусад хууль бус үйл ажиллагаатай тэмцэх гол хэрэгсэл бол реформ гэж үзээд түүнд ихээхэн найдвар тавьж байсныг тэдний нийтлэлүүдээс ажиглаж болно. Эрэн сурвалжлагчид өөрсдийн нийтлэлд ямар нэг асуудлыг шийдвэрлэх практик зөвлөмж дэвшүүлж, арга замыг эрж хайж, тусгахыг зорилго болгоогүй, харин аливаа зохион байгуулалттай гэмт хэрэг, улс төрийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагаатай холбоотой байдаг гэж үзээд гол төлөв нийгмийн ухамсарт хандаж, тэдний тус дэмжлэгийг авахыг эрхэмлэдэг байжээ.

«Талбар» сэтгүүлээс гадна «Комполитэн», «Кольерс», «Саксес», «Эврибодиз», «Маккьюрс», «Мансиз», «Леслиз» зэрэг олон хувиар хэвлэгддэг, нийтийг хамарсан сэтгүүлүүд тухайн үеийн Америкийн сэтгүүл зүй дэх илчлэн шүүмжлэх, эрэн сурвалжлах чиглэлийн сэтгүүлчдийн индэр болж байв. Дээрх сэтгүүлүүдийн нийтлэлийн сэдвийн хүрээ өргөн, олон янзын асуудлыг хөндөж байснаараа онцлогтой юм. Тухайлбал, «Кольерс» сэтгүүл анагаах ухааны салбар дахь хуурамч эм үйлдвэрлэгчдийн хууль бус үйл ажиллагааны эсрэг тэмцэж байсан цөөн тооны тогтмол хэвлэлийн нэг. 1905 оны 10-р сарын 7-ны өдрийн дугаарт сэтгүүлч Сэмюэль Гопкинс Адамс «Америкийн агуу их хуурамч үйлдэл» өгүүлэл

нийтэлж, хуурамч эм үйлд-вэрлэгчдэд хүчтэй цохилт өгчээ. Тэр хөдөлшгүй бодит баримтад тулгуурлан патент авч, сонин хэвлэлээр өргөн сурталчилж буй эмнүүд өвчтнүүдийг эдгээхийн оронд их хэмжээний мансууруулах бодис, химийн хортой элементүүдийг агуулдаг учраас эрүүл мэндийг нь улам хордуулж, хүчтэй сөрөг нөлөө үзүүлж буйг баталж чадсан юм. Үүний үр дүнд өгүүллийн нэр нь хүртэл тэр үеийн хамгийн түгээмэл уриа болон хувирсан ажээ.

1909 онд «Кольерс» сэтгүүл Аляскагийн засаг захиргаа байгалийн нөөцийг дамлан худалдаж буй хууль бус үйл ажиллагааны эсрэг тэмцэж эхэлжээ. Сэтгүүлч К. П. Коноллийн «Цайруулагч багсад зориулсан томоохон ажлууд» өгүүлэлд сенатын гишүүн Баллинжер Аляскагийн нутаг дэвсгэрийг санаанд багтамгүй бүдүүлгээр дур мэдэн дамлан наймаалж буйг илчлэн гаргасан нь олон түмэнд бөмбөг дэлбэрснээс ч хүчтэй нөлөө үзүүлжээ. «Саксес» сэтгүүл Эптон Синклерийн Чикагогийн мал нядлах газрууд дахь хөдөлмөрийн аймшигтай нөхцлийг тод томруун харуулсан алдарт «Ширэнгэ» романыг нийтэлж байсан бол 1905 онд «Эврибодиз» сэтгүүлд сэтгүүлч Ч.Э. Расселлийн арилжаа наймааны томчууд ядуучуудыг яаж дарамтлан мөлжиж, мөнгө хийж буйг тусгасан «Хорвоогийн хамгийн том трест» цуврал өгүүлэл нийтлэгджээ. 1907 онд гарсан сэтгүүлч Лоусоны «Галзуурсан санхүү» цуврал өгүүлэл нь энэ сэтгүүл хоромхон зуур борлогдоход хүргэж, түүний хэвлэгдэх хувь нь асар богино хугацаанд хагас саяд хүрэхэд нөлөөлсөн түүхтэй юм.

«Космополитэн» сэтгүүл ч тэднээс хоцрохыг хүссэнгүй. 1906 оны 3-р сард Филлипсийн шуугиан дэгдээсэн «Сенатын гишүүн урвасан нь» өгүүллийг нийтэлж ихээхэн ашиг олж, нэр хүнд нь дээшилсэн ажээ. «Хэмптонс» сэтгүүлд сурвалжлагч Рета Чайлд Дорр эмэгтэйчүүдийн тэгш эрхийн талаар цуврал нийтлүүлж, Америкийн зөвхөн эмэгтэйчүүд төдийгүй, эрэгтэйчүүдийг хүртэл цочирдуулж байсан юм. Ийм томоохон амжилтанд хүрч олон түмний талархлыг хүлээж байсан жишээ баримтыг тухайн үеийн сонин, сэтгүүлээс олныг иш татаж болох байна.

Энэ үеийн тогтмол хэвлэлийн үйл ажиллагаанд тод ажиглагддаг өөр нэг онцлог шинж бол сонин, сэтгүүлийн хуудаснаас зөвхөн сэтгүүлчид төдийгүй уншигчид ч санал бодлоо илэрхийлж, идэвхтэй оролцож байсан явдал мөн. Ялангуяа «Амэрикэн мэгэзин» (1906) сэтгүүл олон нийтийн санаа бодолд идэвхтэй түшиглэж, дугаар болгонд уншигчдын захидал, нийтлэлийн талаарх санал бодлыг нийтэлдэг «Оо энгэсгийн хүүдий» **булан** гаргаж, мөн редакцийн өгүүлэл, тайлбарыг «Соготой байшинд» нэрээр нийтэлж байв. Үүнээс гадна энэ сэтгүүл ерөнхийлөгч Теодор Рузвельттэй томоохон маргаан өрнүүлж байсан бөгөөд тэр түүний илчлэн шүүмжлэгчид, эрэн сурвалжлагчдыг анх удаа «бохир заваан бүхнийг илчлэгчид»¹ гэж нэрлэсэн юм. Үүний дараа энэ нэр томъёо Америкийн болон Европын сэтгүүл зүйд нэвтэрсэн түүхтэй ажээ.

Эрэн сурвалжлагчдын энэхүү хөдөлгөөн нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг

зөвхөн Америкт төдийгүй бусад оронд хөгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлжээ. Тиймээс эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх суурийг тавьсан шинэ бичлэгийн төрөл зүйл бол **илчлэн шүүмжлэх өгүүлэл** байсан гэж зоригтой хэлж болно. Энэ бичлэгийн төрөл зүйлээр бичиж байсан сэтгүүлчдийн уран бүтээлийн гол онцлог нь үнэн бодитой, шударга, ямар ч асуудалд тал тохой татахгүй ханддаг, тэнцвэрт байдлыг өндөр төвшинд хадгалдаг явдал байлаа. Ийм өгүүлэл сонгон авсан сэдвийг хэн нэгэн өөрийг дээрэмдэхийг, эсвэл хуурч мэхлэхийг үл хүсэгч жирийн уншигчийн өмнөөс өгүүлэх боломж олгосон ажээ. Үүний тод жишээ бол «Вашингтон пост» сонины сэтгүүлчид Карл Бернстайн, Боб Вудворд нар илчлэн шүүмжлэх өгүүллийн төрлөөр бичсэн цуврал нийтлэлийн үр дүнд алдарт «Уотергейт»-ийн хэргийг илчилж, АНУ-ын ерөнхийлөгч Ричард Никсоныг огцруулж чадсан явдал юм.

Мөн Японы сэтгүүл зүй дэх «бохир заваан бүхнийг илчлэгчдийн» үйл хэргийг үргэлжлүүлэгчдийн ч байр суурь, үйл ажиллагаа судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг. Оросын «Совершенно секретно» («Маш нууц») сонинд тэмдэглэснээс үзвэл энэ орны сэтгүүл зүй өндөр албан тушаалтнуудын зүгээс үзүүлж буй янз бүрийн саад бэрхшээлийг үл харгалзан тэдний хууль бус үйл ажиллагаа, мафийн сүлжээ, гэмт хэрэг зэрэг аливаа асуудал, томоохон үйл явдлын талаар байнга бичиж, мэдээлдэг байна. Түүнчлэн Герман зэрэг Европын орнуудын эрэн сурвалжлах сэтгүүл зүй ч ихээхэн үр ашигтай

ажилладгийг хэлэх хэрэгтэй. Энэ бүхнээс үзэхэд өнөөдөр эрэн сурвалжлах сэтгүүл зүй дэлхийн олон оронд хэвийн үзэгдэл болж, эрэн сурвалжлагчдын гол бичлэгийн төрөл зүйл нь илчлэн шүүмжлэх шинжтэй өгүүлэл байдгийг онцлон тэмдэглүүштэй. Ер нь ийм чиглэлийн аливаа нийтлэл хамгийн уншууртай, олон түмний санаа бодол, хүсэл сонирхолд нийцдгийг судлаачид нэг бус удаа тэмдэглэсэн байдаг.

ХІХ зууны дунд үеэс Оросын утга зохиол, сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн аргаар бичигдсэн бүтээлүүд гарч эхэлсэн. Тухайн үеийн нийгмийн бодит байдалд ихээхэн шүүмжлэлтэй хандаж, олон түмний санаа бодлыг зовоож байсан чухал асуудлуудыг дэв-шүүлэн тавьж, томоохон дүгнэлт хийсэн бүтээлүүдийн тоонд А.С.Пушкины «Пугачевын түүх», А.П.Чеховын «Сахалины арал», Ф.М.Достоевскийн «Түймэр», В.Г. Короленкогийн «Мултаны өргөл», В.А.Гиляровскийн «Москва ба москвачууд», «Хогийн доторх хүмүүс» зэрэг бүтээлүүдийг зүй ёсоор оруулдаг. Тэд өөрсдийн уран бүтээлд зөвхөн зохиолч, нийтлэлчийн хувьд төдийгүй сэтгүүлч-эрэн сурвалжлагчийн хувьд дахин давтагдашгүй ул мөрөө үлдээсэн бөгөөд ихэнх тохиолдолд энэ гурван шинжийг ур чадварын өндөр төвшинд хослон хэрэглэсэн байдаг. Оросын сэтгүүл зүйг судлаачид Пугачевын бослогын учир шалтгаан, үр дагаварыг задлан шинжилсэн А.С.Пушкины «Пугачевын түүх» алдарт романыг эрэн сурвалжлах чиглэлээр бичигдсэн анхны бүтээл гэж үздэг. Энд зохиогч янз бүрийн баримт бичиг, түүний дотор 1773

оны тунхаглал, цэргийн удирдагчдын тушаал, захидал, олон түмний дунд тархсан цуу яриа, явган шог, лавлах материал, хүмүүсийн намтар, газар зүйн талаарх мэдээлэл, түүхийн баримт, домог, гэрчүүдийн мэдээлэл, баартын дүр, хөрөг таталбар зэрэг асар их хэмжээний баримт материал цуглуулж, түүнд дүн шинжилгээ, тайлбар хийсэн нь эрэн сурвалжлах арга, ажиллагааг оновчтой ашигласныг харуулж байна. Мөн Ф.М.Достоевский 1862 онд Петербургт гарсан аймшигтай түймрийн шалтгааныг эрэн сурвалжилсан «Түймэр» цуврал өгүүлэл, В.Г.Короленкогийн Удмуртын Мултан тосгоны тариачдыг хилс хэрэгт хэлмэгдүүлэн шорон гянданд хорьж, хууль бус шүүх ажиллагаа явуулсныг 10 сарын турш эрэн сурвалжилж бичсэн «Мултаны өргөл» цуврал өгүүлэл, А.П.Чеховын Сибирь болон Сахалин аралд цөллөгдсөн хүмүүсийн аймшигт амьдрал, нөхцөл байдлыг судалж бичсэн «Сахалины арал», «Сибирь нутгаар» аян замын тэмдэглэл, Москвагийн оршин суугчдын дундах баян хоосны ялгаа, гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаа, аваар осол зэрэг олон асуудлыг тусгасан В.А.Гиляровскийн «Москва ба москвичууд», «Хогийн доторх хүмүүс», «Гоголийн мөрөөр» зэрэг олон арван цуврал сурвалжлага нь А.С.Пушкины эхэлсэн эрэн сурвалжлах ажлыг үргэлжлүүлж, Оросын

сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүйг эрчимтэй хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Энэ бүтээлүүдийг XIX зууны эхэнд гарч байсан «Северная пчела», «Современник», «Русское слово», «Русские ведомости», «Русское богатство», «Новое время», «Московский листок» сэтгүүлд нийтлүүлж байсан нь богино хугацаанд олон түмний хүртээл болж, тэдний сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж,

тодорхой үр дүнд хүрч байжээ. Ер нь Октябрийн хувьсгалын өмнөх үед эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд нийтийг хамарсан нийгэм-улс төр, эдийн засаг, соёл-утга зохиолын чиглэлийн сэтгүүлүүд томоохон үүрэг гүйцэтгэж, илчлэн шүүмжилсэн, задлан шинжилсэн нийтлэлээрээ

«
**«Вашингтон пост» сонины
сурвалжлагчид Карл
Бернштейн, Воб Вудворд нар
ерөнхийлөгч Ричард Никсон
сөрөг хүчнийхэн байрлаж
байсан буудалд тагнах чагнах
хэрэгсэл тавьсаныг илчлэн
шүүмжилсэн цуврал өгүүлэл
нийтлэлүүлсэний үр дүнд
ерөнхийлөгчийг огцруулсан
билээ.**

нийгэмд томоохон нөлөө үзүүлж байсан юм. Өнөдөр Оросын шинэ үеийн эрэн сурвалжлагчид утга зохиол, сэтгүүл зүйн сонгодгуудын эх сууриа тавьсан эрэн сурвалжлах, илчлэн шүүмжлэх үйл ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж байна.

Сэтгүүл зүй судлаачид 1970-аад оныг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн оргил үе гэж нэрлэсэн байдаг. «Вашингтон пост» сонины сурвалжлагчид Карл Бернштейн, Воб Вудворд нар ерөнхийлөгч Ричард Никсон сөрөг хүчнийхэн байрлаж байсан буудалд тагнах чагнах хэрэгсэл тавьсныг илчлэн шүүмжилсэн цуврал өгүүлэл

нийтлэлүүлсэний үр дүнд ерөнхийлөгчийг огцруулсан билээ. Энэ бол дэлхий дахины сэтгүүл зүйн түүхэнд эрэн сурвалжлагчид ямар ч өндөр албан тушаалтны хууль бус үйл ажиллагааг илчилж чаддаг, бас хэвлэл мэдээллийн хэрэгсэл нэгдсэн улсын ерөнхийлөгчийг хүртэл огцруулахад нөлөөлж чаддагийн бодит жишээ мөн.

1980-аад оноос Латин Америк, Азийн орны сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүй нэлээд эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд үүний бодит жишээ бол 2000 онд Филиппиний хэсэг эрэн сурвалжлах сэтгүүлч ерөнхийлөгч Жозеф Эстрадагийн авилгалын хэргийг ил-

рүүлж, түүнийг хугацаанаас нь өмнө огцруулж чадсан явдал юм. Тус улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвийн захирал Шейла Коронелагийн удирдсан сэтгүүлчид ерөнхийлөгч Ж.Эстрадагийн нууцлаг эд хөрөнгийг найман сарын турш эрэн сурвалжилсаны үр дүнд бэлтгэж, сонинд нийтлүүлсэн цуврал сурвалжлага нь ерөнхийлөгчийн эсрэг шүүх ажиллагааны гол үндэслэл, нотлох баримт нь болжээ. Энэ бол Азид эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үр дүнд бие даасан улсын ерөнхийлөгч огцорсон анхны тохиолдол болсон юм. Тиймээс нэр хүндтэй «Asia week» сэтгүүл Ш.Коронелаг «Азийн томоохон хээл хахуультай тэмцэгч»² гэж тодорхойлсон ажээ. Өнөөдөр Азийн

орнуудад эрэн сурвалжлах сэтгүүл зүй нэлээд амжилттай хөгжиж байгааг дээрх баримт харуулж байна.

Бразилийн «Жорнал де Бразил» 1991 оноос эхлэн төр засгийн өндөр албан тушаалтнууд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж буйг илчлэх кампанит ажлыг өрнүүлсэн бөгөөд сурвалжлагч М.Роша Эдийн засгийн яамны мэдээллийн санд компьютерийн сүлжээгээр дамжин орж, нийгмийн эмзэг бүлгийн хэргэцээнд зориулсан мөнгийг ерөнхийлөгч Ф.Коллорын эхнэрийн хамаатан саднуудад тарааж өгсөнийг илчилжээ. Мөн ерөнхийлөгчийн томоохон хээл хахуультай холбоотой

«

Асуудал дэвшүүлж, задлан шинжилсэн, баримт мэдээлэл сайтай томоохон хэмжээний чанартай нийтлэлүүд аяндаа сонины хуудаснаас шахагдаж эхэлдэг бөгөөд ерөөсөө олон түмэн тийм материалыг хүлээж авах сонирхолгүй гэсэн сэтгэгдлийг хэвлэн нийтлэгчдэд төрүүлдэг.

»

үйл ажиллагааг ч илрүүлж чадсан юм. Энэ кампант ажлыг цаашид долоо хоног тутмын «Вежа» сэтгүүл үргэлжлүүлж Ф.Коллорыг төрийн тэргүүнээс зайлуулахад нөлөөлжээ. Энэ бол Латин Америкийн сэтгүүл зүйд урьд өмнө ажиглагдаж байгаагүй томоохон амжилт юм.

Барууны эрэн сурвалжлах сэтгүүл зүйд харьцангуй түгээмэл хэрэглэдэг үйл ажиллагааны өөр нэг хэлбэр бол **папарацци** буюу нууц байдлаар зураг авах, ажиглалт хийж мэдээлэл цуглуулах явдал юм. Энэ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх суурийг тавигчид болох «бохир заваан бүхнийг илчлэн шүүмжлэгчидтэй» харьцуулахад арай өөр нөхцөл байдлын улмаас үүссэн гэж үздэг. Тодруулбал, зах

зээлийн ширүүн өрсөлдөөний үед оршин тогтох, сонины хэвлэгдэх хувь, захиалагчдын тоог нэмэгдүүлэх, борлуулалтыг сайжруулахын төлөө тэмцэл үүнд хүчтэй нөлөөлсөн. Мэдээж сэтгүүл зүйд хийгдэж буй аливаа шинэлэг алхам, түүний дотор папараццийн үйл ажиллагаа зэрэг ихэнх тохиолдолд сөрөг үр дагавар дагуулдаг үйлдлийг олон түмний хэрэгцээ, сонирхлыг үл харгалзан хийх боломжгүй. Папараццуудын хийж байгаа зүйл нь зөвхөн сонин хэвлэлд төдийгүй түүнийг хүлээн авагчид, бас уран бүтээлчдийн «золиос» болж буй янз бүрийн «одууд», алдар цуутай хүмүүст ч ашигтай юм. Судлаач Л.Д.Болотова энэ талаар «"Одууд гялалзах" нь хэн нэгэнд хэрэгтэй юм... Үнэн хэрэг дээрээ хэн нэгэнд бус бүх хүнд хэрэгтэй. Юуны өмнө "одуудын" өөрсдөд нь хэрэгтэй. Учир нь тэднийг хүмүүс мэддэг, харж сонирхдог, хайрлаж дурладаг болно. Энэ механизм зах зээлийн "хэрэгцээ хүсэл сонирхол төрүүлдэг" гэсэн сонгодог зарчмын дагуу ажилладаг учиртай юм. Нэг талаар, улс төр, бизнес, урлаг, спортын "одууд" өөрсдийгөө өдөр тутам сурталчлах, олон түмэнд "нээн харуулахыг", нөгөө талаар, олон түмэн өөрсдийн "баатруудын" талаар мэдэхийг хүсдэг. Энэ хоёрын хооронд хэвлэл мэдээллийн хэрэгсэл оршдог бөгөөд тэр нь аль алины захиалга, хүсэл сонирхлыг ямар нэг хэмжээгээр биелүүлэхэд бэлэн байдаг. Сүүлийн жилүүдэд алдар цуутай хүмүүсийн тухай дагнан тусгадаг төрөлжсөн сонин хэвлэлийн тоо эрс нэмэгдсэн нь санамсаргүй зүйл биш юм. Тиймээс уншигчдын тодорхой хэсэг нь

мэдээллийг амар хялбар хэлбэрээр (өөрөөр хэлбэл, унших бус үзэх, эсвэл цоожны нүхээр харах) хүлээж авахыг хүсдэг болжээ. Тэгвэл энэ бүхнээс үзэхэд орчин үеийн нийгэмд "папараццууд" гэж нэрлэдэг дээд зиндааныхны талаар шуугиан дэгдээсэн мэдээлэл бэлтгэдэг сурвалжлагчид хүссэн хүсээгүй оршин тогтнох нь тодорхой юм»³ гэж тэмдэглэсэн байдаг.

Папараццийн аливаа үйл ажиллагаа сонин хэвлэлийн хувьд эерэг болон сөрөг үр дагавартай гэдэг нь тодорхой. Сонины борлуулалтанд нөлөөлж, редакцид их хэмжээний ашиг оруулдаг, шуугиан дэгдээж олон түмэн тухайн сонин хэвлэлд анхаарлаа хандуулах зэрэг сайн талтай юм. Харин папараццийн материалууд хэт ихдэх нь сонины нийтлэлийн чанарт бүхэлдээ нөлөөлж, утга учир багатай, үлбэгэр болж, мэдээллийн ач холбогдолыг бууруулж, сонин хэвлэл зугаа цэнгээний талбар болон хувирахад нөлөөлдөг. Асуудал дэвшүүлж, задлан шинжилсэн, баримт мэдээлэл сайтай томоохон хэмжээний чанартай нийтлэлүүд аяндаа сонины хуудаснаас шахагдаж эхэлдэг бөгөөд ерөөсөө олон түмэн тийм материалыг хүлээж авах сонирхолгүй гэсэн сэтгэгдлийг хэвлэн нийтлэгчдэд төрүүлдэг. Өнөөдөр зөвхөн Барууны төдийгүй манай сэтгүүл зүйд ч тийм хандлага ажиглагдаж байгааг төвөггүй мэдэрч болно. Тиймээс хэвлэл мэдээллийн зах зээлд чанартай хэвлэлийг дуулиан шуугиан хөөцөлдсөн гудамжны «шар» хэвлэл ямар нэг хэмжээгээр шахаж эхэлсэн нь нууц биш юм.

Энэ бүхний улмаас илчлэн шүүмжлэх зорилго бүхий эрэн сурвалжлах сэтгүүл зүй өөрийнхөө нүүр царайг тодорхой хэмжээгээр өөрчлөхөд хүрсэн юм. Цөөн хувиар хэвлэгддэг улс төрийн чиглэлийн чанартай сонин хэвлэл улс төр, экологи, бизнес, төр засгийн байгууллагуудын (эмнэлэг, сургууль, шорон г. м.) үйл ажиллагааг идэвхтэй эрэн сурвалжилж байхад зугаа цэнгэл хөөцөлдөж, олон нийтийн сэтгэл зүйгээр тоглодог сонин хэвлэл папараццийн материалуудыг нийтлэхийг чухалчилдаг болов.

Манай сэтгүүл зүйд папараццууд тун саяхнаас идэвхтэй нэвтэрч эхэлсэн бол Барууны ихэнх оронд олон арван жилийн өмнө эх сууриа тавьсан түүхтэй юм. Папараццууд бол өөрийн ажлын төлөө улайран хөөцөлддөг ер бусын хүмүүс. Жирийн нэг папараццийг алхам тутамдаа «золиослогч»-ийн араас улайран зүтгэж, аль нэг байшин барилга, орд харшийн үүдэнд аппаратын товчлуурыг дарахад бэлэн зогсож байдаг, яару сандруу, мөнхийн завгүй явдаг, ядарч сульдсан нүүр царайтай хүмүүс гэж хэлж болно. Тэд барын анчин адил «олзны» төлөө нойр, хоолгүй хэдэн хоног ч хүлээхэд бэлэн байдаг. Нэр цуутай хүмүүсийг согтуу хөлчүү, эсвэл нууц амраг, найз нөхөд, дайснуудын хамт байхад нь, эсвэл ёс бус үйлдэл дээр нь «барихын» тулд ямар ч хүнд нөхцөлд ажиллах,

тэвчээртэй хүлээх явдал папараццуудын хувьд энгийн үзэгдэл байдаг.

Хүн төрөлхтний санаа сэтгэлийг зо-воосон, нийгмийн өмнө тулгамдсан, зайлшгүй шийдвэрлэхийг шаардсан асуудлууд папараццуудад сонин биш. Экологийн асуудал, дайн байлдааны зөрчил сөргөлдөөн, улс төрчүүд болон бизнесменүүдийн хоорондох хуйвалдаан, хүүхэд залуучуудын хүмүүжил тэдэнд огт хамаагүй гэж хэлж болно. Тэгсэн мөртлөө тамирчид, урлагийн «одууд», улс төрийн зүтгэлтнүүдийн хувийн амьдралын элдэв асуудал ямагт тэдний анхаарлын төвд байдаг. Заримдаа ямар ч ач

«
*Гэхдээ нэр цуутай
хүмүүсийн хувийн амьдрал,
«дотоод хэрэг»-т
унишгчийн анхаарлыг
«хүчээр» татахыг
оролддог сонин, сэтгүүл
цөөнгүй бий.*

»

холбогдолгүй баримт сэлт, нарийн ширийн зүйлийг сонирхдог нь нууц биш юм. Папараццид нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл бол улс орныг, эсвэл үндэстнийг үнэлэх, алдаршуулах, сурталчлах асуудал огт биш бөгөөд өөрийнхөө авсан зураг, эх бичвэрийн төлөө яаж ахиухан мөнгө олж авах вэ гэсэн сонирхол мөн.

Өнөөдөр ихэнх сонин хэвлэл өөрт боломжийн ашиг оруулж чадахуйц шуугиан дэгдээсэн материалын төлөө хангалттай шагнал төлөхөд бэлэн байна. Папараццууд үүнийг далимдуулан өөрсдийн нийтлэлийн үнэн бодит байдал, зургийн чанарт тэр болгон анхаардаггүй. Ялангуяа зургийн тайлбар нь цэвэр зугаа цэнгээний зорилгын үүднээс бичигдсэн нэлээд хөнгөн шингэн шинжтэй байдаг нь түгээмэл юм.

Нөгөө талаар папараццууд амархан «олзны» араас хэт улайран хөөцөлдөж, цаг хугацаанд шахагдах үед сэтгүүлчийн ёс зүйн талаар мартах тохиолдол ч цөөнгүй гардаг. Хүний хувийн амьдралд хөндлөнгөөс оролцож, бүдүүлгээр халдахыг олон оронд зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай төдийгүй Үндсэн хуулийн хүрээнд хариуцлагад татдаг. Энэ бол зөв зүйтэй, үндэслэлтэй хязгаарлалт мөн. Учир нь хүний хувийн амьдралыг үл хүндэтгэх явдал нэр цуутай хүмүүсийн сэтгэл зүйд хүчтэй сөрөг нөлөө үзүүлэхээс гадна заримдаа жинхэнэ сүйрэл, эмгэнэлт явдалд хүргэж болно. Тухайлбал, бид Диана гүнжийн эмгэнэлтэй үхлийг мартаагүй байна. Шинжээчдийн дүгнэлтээс үзэхэд үүнд машины араас хөөж, хөдөлгөөний хэвийн байдалд саад учруулсан папараццууд буруутай ажээ. Тэд мөргөлдсөн машин дотор цус нөжинд холилдон үхсэн байсан гүнжийн зургийг авч, «бүтээлээ» АНУ-ын томоохон «шар» сэтгүүл болох «Нэшнл инкуайер»-ийн редактор Стив Коцад худалдахыг оролдож байв. Гэхдээ гүнжийг хүндэтгэсэн редактор хүний зовлонгоор тоглож их хэмжээний мөнгө олох гэсэн сэтгүүлчдийн саналаас эрс татгалзаж, тэднийг хөөн зайлуулсан баримт бий. Папараццийн зарчмаар амьдарч буй сэтгүүлчид заримдаа хүн чанараа алдаж, араатан шиг аашилдгийн жишээ энэ мөн. Өнөөдөр нийгэмд папараццуудад хандах хандлага ихээхэн өөрчлөгдөж, тэднийг ёс суртахууны энгийн хэм хэмжээг алдсан хүмүүс гэж үздэг болсон нь санамсаргүй зүйл биш юм.

Орчин үед Орост болон манай оронд Америкийн нэгэн адил эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хоёр үндсэн чиглэл бий. Нэг дэх нь «бохир заваан бүхнийг илчлэн шүүмжлэх» Америкийн туршлагатай нэлээд төстэй боловч Барууны эрэн сурвалжлагчдаас ихээхэн ялгаатай. Үүний гол шалтгаан нь манай орны эрэн сурвалжлах сэтгүүлчдийн зорилго, үйл ажиллагаа явуулж буй нөхцөл, орчин нь гадаадын эрэн сурвалжлагчдынхаас эрс өөр байгаатай холбоотой юм. Үүнийг Оросын нэрт сэтгүүлч А.Константинов маш соргогоор ажигласныг дараах мөрүүдээс мэдэж болно. Тэрбээр «...юны өмнө эрэн сурвалжлах технологийг хэрэглэх салбар, хүрээгээрээ эрс ялгаатай. Манайд гол төлөв янз бүрийн гэмт хэрэг, авилгал, эсвэл түүнтэй төстэй үйлдлүүд байдаг. Тэгвэл Баруунд эрэн сурвалжлах ажиллагаа бидний бодлоор дэндүү энгийн юм шиг үйл явдлын хүрээнд явагддаг. Ирээдүйд бид бас гадаадын сэтгүүлчид шиг болохыг үгүйсгэх аргагүй. Одоогийн байдлаар бидэнд тулгарч буй хамгийн гол асуудал бол Барууны эрэн сурвалжлагчид үйл ажиллагаа явуулдаг шиг таатай нөхцөл, боломж бүрдээгүй байна. Тухайлбал, тэдэнд эрэн сурвалжлах ажилд зориулан ямар нэгэн сангаас материаллаг тусламж үзүүлдэг. Хүрэлцээтэй зардал, мөнгөтэй сэтгүүлч өдөр тутмын талхны мөнгө олохыг бодохгүйгээр хангалттай удаан хугацаанд тайван ажиллаж болно. Манай оронд сэтгүүлч эрэн сурвалжлах чиглэлийн томоохон хэмжээний чанартай материал бэлтгэх явцад өдөр тутмын талхны хэдэн мөнгийг олохын тулд давхар

олон мэдээ материал бэлтгэх шаардлага зайлшгүй тулгардаг. Манайд Барууны редакциуд шиг сэтгүүлчид урьдчилж мөнгө төлж, илтгэл хүлээлгэж сураагүй. Ер нь Оросын сэтгүүл зүй Барууны сэтгүүл зүйгээс эрс ялгаатай юм...»⁴ гэж онцлон тэмдэглэсэн нь манай сэтгүүл зүйд нэгэн адил хамаарна. Өнөөдөр Монголын сэтгүүл зүйд яг дээрхийн адил дүр зураг, нөхцөл байдал оршиж байгааг хүн бүхэн мэднэ.

Дэлхийн ихэнх оронд оршиж буй эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хоёр дахь гол чиглэл нь «шар» ба «шарлаж» буй хэвлэлийн үндсэн шинж болох папараццийн үйл ажиллагаа юм. Манай оронд «папараццийн сэтгүүл зүй» янз бүрийн шалтгааны улмаас зохих төвшинд хөгжиж чадаагүй нь ойлгомжтой. Гэхдээ нэр цуутай хүмүүсийн хувийн амьдрал, «дотоод хэрэг»-т уншигчийн анхаарлыг «хүчээр» тата-хыг оролддог сонин, сэтгүүл цөөнгүй бий. «Хүмүүс», «Дээдсийн хүрээлэн», «Дээдсийн амьдрал», «81-р суваг», «Шар сонин» тэргүүтэй олон сонинд нийтлэгдэж буй зохиомол ярилцлагаас эхлээд хүмүүсийн хувийн амьдралын онцын ач холбогдолгүй баримт сэлтийг тусгасан мэдээ материалууд үүний тодорхой жишээ мөн. Мөн «Монголын мэдээ» (1999, № 34) сонины сурвалжлагч С.Зориг агсаны эхнэр Б.Булганыг цагдаагийнхан Ганцхудагт хоригоор авч явааг тусгасан зургийг нийтэлсэн нь ихээхэн шуугиан дэгдээж, сонины борлуулалтанд хүчтэй нөлөөлж байсныг хэлж болно. Оросын кино, телевизийн чиглэлийн «Долоо хоног» сэтгүүл папараццийн бүтээлд зориулсан

«Тутти-Фрутти» хэмээх тогтмол булантай бөгөөд тэнд гол төлөв хэмжээний хувьд багавтар орчуулгын материалууд, фото зургуудыг нийтэлдэг байна. Жишээ болгон нэрт хөгжимчин Мик Жаггер эхийн хамт амьдардаг өөрийн хүүтэй уулзсан тухай бичвэрийн хэсгээс иш татъя.

«Хүүтэй учрах сэтгэл догдлуулсан уулзалтанд эцэг нь аль болохоор сайн бэлтгэхийг хичээв. Цэцэрлэгт хүрээлэн (тэнд уулзахаар тохирсон) орох замдаа хүүхдийн тоглоомын "The Farmyard" дэлгүүрээс жижиг Лукасад чин сэтгэлээсээ зориулан хэд хэдэн бэлэг худалдан авлаа. Ричмондын цэцэрлэгт хүрээлэнд аз жаргалд бялхсан гурвуулаа гурван цаг орчим хугацааг тун амжилттай өнгөрөөлөө. Гэрчүүдийн мэдээллээс үзэхэд тэр гурав тоглож, инээж баясан, алиалж үнэхээр баяр баясгалантай байсан ажээ. Энэхүү уулзалт Жаггер Морад хоёр удахгүй нийлэх байх гэсэн сэтгэгдэл төрүүлэхэд хүргэсэн юм. Магадгүй. Гэхдээ цэцэрлэгээс гарахдаа найз нөхөд ёсоор үнсэлцэж салсан Мик болон хүүгээ дагуулсан Лусиана хоёр өөр тийш яваад өглөө. Жаггер өөрийн "Мерседес", Морад "Ягуар" машинд суулаа...»⁵

Энэхүү «ер бусын» («сэтгэл догдлуулсан») уулзалтыг тусгасан эх бичвэрийн хамт таван фото зураг нийтлэгджээ. Үүнээс үзэхэд сэтгүүлч мэдээлэл цуглуулах явцад ажиглалтын аргыг амжилттай хэрэглэсэн бөгөөд фото зурагт дүрслэгдсэн хүмүүс ямар нэг ажиглагч байгааг ер анзаараагүй өнгөрчээ. Мөн тухайн үед алдарт хосын ойр хавьд цэцэрлэгт зугаалж байсан хүмүүсээс авсан мэдээлэлд тул-

гуурласан нь тодорхой байна. Материал бүхэлдээ дүрслэн үзүүлэх зорилготой ажээ. Хэдийгээр сэтгүүлч алдарт хосын ирээдүйн харилцааны талаар таамаглал дэвшүүлсэн боловч тэр нь ямар ч үндэслэлгүй юм. Энд папараццийн материалын онцлог шинж болох хүлээн авагчийг итгүүлэн үнэмшүүлэх зорилгоор ашигласан тодорхой баримтуудад анхаарлаа хандуулах явдал ажиглагддаг. Тухайлбал, тоглоомын дэлгүүрийн болон хоёр машины нэр зэргийг тодорхой бичсэнийг нэрлэж болно.

Папараццийн ийм «санаанаас зохиосон» зүйл нь жинхэнэ эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдлыг бууруулдаг сөрөг нөлөөтэй боловч түүнийг Барууны сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нэг чиглэлд оруулж үздэг байна. Хамгийн гол нь папарацци нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээний хүрээнд ажиллах нь чухал бөгөөд тэдний зарим үйл ажиллагаа нь томоохон үр дүн хүрдэг тохиолдол цөөнгүй байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Энэ бүхнээс үзэхэд манай орны сэтгүүл зүйд Барууны эрэн сурвалжлах сэтгүүл зүйд түгээмэл хэрэглэдэг хоёр чиглэлийн аль аль нь хөгжих эх суурь тавигдсан гэж хэлэх үндэстэй юм.

Дээр өгүүлснийг нэгтгэн дүгнэвэл зарим сэтгүүлч, судлаачийн үздэг шиг эрэн сурвалжлах сэтгүүл зүй бол цоо шинэ зүйл огтхон ч биш олон арван жилийн өмнө Европод эх сууриа тавьж, Америкт улам эрчимтэй хөгжих замаар дэлхий дахины сэтгүүл зүйд төлөвшсөн сэтгүүлчдийн үйл ажиллагааны нэлээд үр нөлөө

бүхий өвөрмөц хэлбэр мөн. Эхлээд зохиолчдын баримтат уран зохиолд, дараа нь сэтгүүлчдийн аян замын тэмдэглэл, найруулал, илчлэн шүүмжлэх цуврал өгүүлэлд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэл тодорхой байр эзэлж байсан бол өнөөдөр сэтгүүлчид бичлэгийн аль ч төрлийг түгээмэл ашиглаж байна.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд XX зууны эхний үеийн эдийн засгийн эрчимтэй хөгжил, реформ, зах зээлийн өрсөлдөөн зэрэг үзэгдлүүд хүчтэй нөлөөлж, нийтийг хамарсан нийгэм-улс төр, эдийн засгийн чиглэлийн сэтгүүл олноор гарах болсон нь чухал үүрэг гүйцэтгэжээ. Өнгөрсөн зууны дунд үеэс эрэн сурвалжлах сэтгүүл зүй дэлхийн олон оронд хөгжих нөхцөл боломж бүрдэж, 1970-аад онд АНУ-ын ерөнхийлөгчийн хууль бус үйл ажиллагааг илчилж, түүнийг огцруулахад нөлөөлснийг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжлийн оргил үе гэж нэрлэдэг юм. Энэ нь Латин Америк, Азийн орнуудад эрэн сурвалжлах сэтгүүл зүй эрчимтэй хөгжихөд нөлөөлж, 1991, 2000 онд Бразил, Филиппиний эрэн сурвалжлагчид улсынхаа ерөнхийлөгчийг огцруулахад гол үүрэг гүйцэтгэсэн нь урьд өмнө үзэгдэж байгаагүй том амжилт мөн.

Манай оронд 1980-аад оны дунд үеэс эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх суурь тавигдаж, өнөөдөр энэ чиглэлээр ажиллах сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо нэмэгдэж, цаашид эрчимтэй хөгжих эрх зүй, нийгэм-эдийн засгийн таатай орчин бүрдэж эхэлж байна.

Ишлэл

1. Качалин А., Урбан А. 1997. Папарацци — следствие или причина. // «Эхо планеты». № 38.
2. Ишлэлийг: Зулькафиль М. 2002. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй. УБ. 10 дахь тал.
3. Болотова Л. Д. 1970. Американский массовый журнал конца XIX века. // Вестн. МГУ, Сер. Журналистика. № 1.
4. Ишлэлийг: Шум Ю. 2000. Журналистское расследование: методические рекомендации. М.
5. Встреча в парке. 2000. // «Семь дней», №41

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Авраамов Д. 2000. Журналистские расследования. Москва.
2. Арифджанов Р. 2001. Журналистское расследование — штучный жанр. // Журналист. №6.
3. Болотова Л.Д. Американский массовый журнал конца XIX века. // Вест. МГУ: Журналистика. 1970, № 1.
4. Качалина А, Урбан А. 1997. Папарацци — следствие и причина. // Эхо планеты. №38.
5. Журналистское расследование. 2001. // Под ред. А. Константинова. СПб. Москва.
6. Зулькафиль М. 2002. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй. Улаанбаатар.
7. Тертыйный А. А. 2000. Журналистские расследования. Москва.

8. Уллмен Дж. 1998. Журналистские расследования: современные методы и техника. Москва.
9. Цэмбэл Д., Цэнджав До. 2000. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд. Улаанбаатар.
10. Шум Ю. 2000. Журналистское расследование: методические рекомендации. Москва.
11. John Ullman. 1998. Investigative Reporting. New-York.
12. William Gaines. 1994. Investigative Reporting. Chicago-Nelson-Hall Publishers.

К вопросу о возникновении и развитии расследовательской журналистики

В данной статье рассматриваются вопросы возникновения и развития расследовательской журналистики в развитых странах мира и факторы, предопределяющие бурный рост расследовательской журналистики в современном мире, ее роль в становлении гражданского общества Монголии. Автор на практическом материале зарубежной расследовательской журналистики исследует цели, задачи, средства, принципы, методы, условия и формы осуществления этого вида деятельности, перспективы развития, особенности проведения расследований отечественными журналистами. Также исследуя традиции и опыт расследательства знаменитых зарубежных журналистов автор делает вывод о том, что зарубежный опыт является одним из важных источников становления современной монгольской расследовательской журналистики.